



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР**

Багш хөгжлийн төв, 11 баг, 6-р хороо,  
Дархан сум, Дархан-Уул аймаг 45059  
Утас/факс: (976) 7037-0011  
Цахим шуудан: dca@da.moc.gov.mn

2024.04.24 № 01/129  
танай 2024.04.02 -ны № 2-10/445 -Т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА О.ХҮРЭЛЧУЛУУН ТАНАА

Соёл, урлагийн салбарын хэмжээнд “Нэг байгууллага-Нэг сайн үйл” аянд нэгдэн зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх тайланг тус газраас хүргүүлж байна.

Хавсралт <sup>3</sup>...хуудастай.

ДАРГА



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

**4524010167**

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын  
2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн  
01/24 тоот албан бичгийн хавсралт

## “GOOD DEEDS DAY-САЙН ҮЙЛСИЙН ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

4289366 1922050017 ГСТ7344

Жил бүрийн дөрөвдүгээр сард олон орны иргэд сайн дураараа нийгмийн сайн сайхны төлөө нийтэд тустай ажлыг үндэсний хэмжээнд өрнүүлэх, олон нийт, иргэд, залуучуудад сайн үйлсийн үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой “Good deeds day-Сайн үйлсийн өдөр”-ийг тэмдэглэн кампанит ажлуудыг зохион байгуулдаг билээ. Энэ хүрээнд Дархан-Уул аймгийн Соёлын 7 байгууллагууд тус аянд нэгдэж 7 арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа. **Үүнд:**

### Соёл, урлагийн газар:

1. Соёлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Соёлын байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд соёлын олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо” ТББ-тай хамтран боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



*Тус хөтөлбөрийн хүрээнд Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч С.Одонцоо Хотон угсаатны бий биелгээ, ахуйн зан заншлыг 20 гаруй хүүхэд, эцэг эхчүүдэд сургалаа. /2024.04.08/*

### Залуучууд театр:

2. Дархан-Уул аймгийн Залуучууд театрын шинэ уран бүтээл “Муурын байшин” хүүхдийн жүжиг, Залуучууд театрын дэргэдэх “Шонхоодой циркийн шилдэг үзүүлбэрүүд 2” тоглолтыг зорилтот бүлгийн 8 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулсан. /2024.04.13,14/



**Аймгийн Төв номын сан:**

3. Дархан зах, ОУ-ын худалдааны төв, Оргил худалдааны төвд үйлчлүүлж буй олон нийт, иргэдийн дунд "Гэр бүлийн номын худалдаа" болон Төв номын санд уншигчийн карт үнэ төлбөргүй нээх үйл ажиллагааг зохион байгуулсан. /2024.04.23/



**Хүүхдийн номын ордон:**

4. ЕБС-ийн сурагчдын дунд ном унших соёлыг түгээн дэлгэрүүлэх, номоор дамжуулан хүүхэд залуусыг соён гэгээрүүлэх, зохиолч, хэвлэн нийтлэгчдийг алдаршуулах, тэдний шинэ бүтээлүүдтэй уншигчдыг танилцуулах зорилгоор "Номтой өдөр" арга хэмжээ, "Зохиолч уншигчдын уулзалт"-ыг зохион байгууллаа. /2024.04.23/



**Аймгийн Музей:**

5. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо" ТББ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон эцэг эхчүүдэд "Нада-г урлая" боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж 12 хүүхэд 8 эцэг эхчүүдийг хамруулсан. /2024.04.04/



**Хонгор сумын Соёлын төв:**

6. Соёлын төвийн номын санч “Арвин тун” эмийн сантай хамтран 16 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 28 хүүхэд, сумын 12 иргэнд нийт 40 иргэнд дархлаажуулалт “Витаминжуулалт”-ын ажлыг зохион байгууллаа. /2024.04.24/



**Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл:**

7. Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2024.04.23-ны өдөр Дархан зах, ОУ-ын худалдааны төв, Оргил худалдааны төвүүдээр үйлчлүүлж буй иргэдийн дунд танин мэдэхүй хөгжөөнт “АХА” тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд нийт 50 гаруй иргэд оролцож ялагчийг 1, 2-р байр эзлүүлэн нийт 6 иргэдийг шагнаж урамшуулав.



**ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:**

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

*Б.Долгормаа* Б.ДОЛГОРМАА

**ХЯНАСАН:**

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

*С.Туяа*  
С.ТУЯА